



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 47 (380)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Агентлаг байгуулах тухай*
- *Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрыг байгуулах тухай*
- *2005 оныг "Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил" болгон зарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны арванхоёрдугаар сарын 23 №47 (380)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 447. | Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  | 872 |
| 448. | Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Ялтан шилжүүлэн өгөх тухай" гэрээг соёрхон батлах тухай | 872 |
| 449. | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                                   | 873 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 450. | Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай                        | Дугаар 28 | 873 |
| 451. | Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай         | Дугаар 29 | 873 |
| 452. | Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай                      | Дугаар 30 | 874 |
| 453. | Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай                             | Дугаар 31 | 874 |
| 454. | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Дугаар 32 | 874 |
| 455. | Үндэсний статистикийн газрын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай         | Дугаар 33 | 875 |
| 456. | Консулын газар байгуулах тухай   | Дугаар 34 | 875 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |  |            |     |
|------|--|------------|-----|
| 457. | Ерөнхий хувь нийлүүлэгчийг томилох тухай   | Дугаар 204 | 876 |
| 458. | Агентлаг байгуулах тухай   | Дугаар 205 | 876 |
| 459. | Засгийн газрын агентлаг байгуулах тухай  | Дугаар 207 | 876 |
| 460. | Ажилд томилох тухай  | Дугаар 208 | 877 |
| 461. | Ажилд томилох тухай  | Дугаар 209 | 877 |
| 462. | Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай | Дугаар 214 | 877 |
| 463. | Хэлэлцээр батлах тухай   | Дугаар 217 | 879 |
| 464. | Зарим хүнийг ажлаас чөлөөлөх тухай   | Дугаар 218 | 880 |
| 465. | Зарим хүнийг ажилд томилох тухай   | Дугаар 219 | 880 |
| 466. | Ажилд томилох тухай  | Дугаар 220 | 881 |
| 467. | Ажилд томилох тухай  | Дугаар 221 | 881 |
| 468. | Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрыг байгуулах тухай                   | Дугаар 222 | 881 |
| 469. | 2005 оныг "Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил" болгон зарлах тухай     | Дугаар 223 | 882 |
| 470. | Жагсаалтад нэмэлт оруулах тухай  | Дугаар 230 | 882 |
| 471. | Жагсаалтад нэмэлт оруулах тухай  | Дугаар 231 | 882 |



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 12 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулийн 4, 6, 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалт тус тус нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/ уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус;"

2/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/ уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр;"

3/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг /хүснэгт/-ийн 4 дэх заалт:

4. Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоо метр тутамд:					
а/ Алт, цагаан тугалга олборлолт	төг	50.00	100.00	100.00	150.00
б/ Газрын тос олборлолт, цайр, хар тугалга баяжуулах	төг	50.00	100.00	100.00	150.00
в/ Зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	төг	20.00	80.00	50.00	150.00

**2 дугаар зүйл.** "Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай" хуулийн нэрийг "Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай" гэж; Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "0.1" гэснийг "1.0" гэж; "0.5" гэснийг "5.0" гэж; мөн хэсгийн 2 дахь заалтын "10.00" гэснийг "30.00" гэж; 3 дахь заалтын гадаргын усанд хамаарах хэсгийн "1.00" гэснийг "10.00" гэж; "5.00" гэснийг "20.00" гэж; газрын доорхи усанд хамаарах хэсгийн "1.00" гэснийг "30.00" гэж; "20.00" гэснийг "50.00" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн "болон гар худгийн" гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, КАНАД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД БАЙГУУЛСАН "ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ ТУХАЙ" ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Ялтан шилжүүлэн өгөх тухай" гэрээг Монгол Улсын

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 12 дугаар сарын 09—ний өдөр

Улаанбаатар хот

### НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлд дараахь агуулгатай 5.1.12 дахь заалт нэмсүгэй:

"5.1.12. Эх орончдын өдөр: гуравдугаар сарын 1."

**2 дугаар зүйл.** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.11-

ийн "Хүний эрхийг хамгаалах өдөр:" гэснийг "Ардчилал, хүний эрхийн өдөр:" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09—ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь "Эх орон-Ардчилал" эвслийн бүлгийн дүгнэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Батбаярыг Дэд бүтцийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Эдийн засгийн байнгын

хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Ламжавын Гүндалайг Байгаль орчны байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төсвийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг 2004 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09—ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

### Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- 1.Чилхаажавын Авдай
- 2.Батжаргалын Батбаяр
- 3.Жамъяндоржийн Батхуяг
- 4.Рэнцэнгийн Буд

- 5.Даваажавын Ганхуяг
- 6.Ламжавын Гүндалай
- 7.Базарсэдын Жаргалсайхан
- 8.Долоонжингийн Идэвхтэн
- 9.Дүрээзэгийн Одхүү
- 10.Лханаасүрэнгийн Пүрэвдорж
- 11.Цэндийн Сүхбаатар
- 12.Батаагийн Цэрэнбалжир

2.Энэ тогтоолыг 2004 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

### Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнээс, Улсын Их Хурлын гишүүн Рэнцэнгийн Будыг Нутгийн өөрөө удирдах ёсны дэд хорооны бүрэлдэхүүнээс, Улсын Их Хурлын гишүүн Рэгжийбуугийн Нямсүрэнг Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Улсын Их Хурлын гишүүн Лүймэдийн Гансүхийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Горчинсүрэнгийн Адъяаг Нутгийн өөрөө удирдах ёсны дэд хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг Хүний эрхийн дэд хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3. Энэ тогтоолыг 2004 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

### Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 3.3 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баатарын Эрдэнэсүрэн, Дэд бүтцийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жанлавын Наранцацралт, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Отгонбаяр, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чойнзонгийн Содномцэрэн нарыг тус тус сонгосугай.

2. "Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай" Улсын Их Хурлын 2004 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн 7 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны даргаар" гэснийг "Байгаль орчны байнгын хорооны даргаар" гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолыг 2004 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

### Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

1/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга: -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд.

2/Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:

-Сангийн дэд сайд;  
-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;  
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын албаны дарга.

3/даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр:

-Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дэд ерөнхийлөгч;  
-Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ажилчдын ҮЭ-ийн холбооны дарга;

-Монголын "Гэгээрэл" ҮЭ-ийн холбооны төлөөлөл.

4/ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч;  
-"Тэхь-Ко" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;  
-"Мах импекс" ХК-ийн дэд захирал.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа 2006 оны 1 дүгээр сард дуусгавар болгохоор тогтоосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

### Үндэсний статистикийн газрын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн газрын зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/ Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх;

2/ Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

3/ Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

4/ УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны зөвлөгч;

5/ МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Статистикийн тэнхмийн эрхлэгч;

6/ Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны ерөнхийлөгч;

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н. ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

### Консулын газар байгуулах тухай

Дипломат албаны тухай хуулийн 6.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа Ерөнхий консулын газрын Эрээн хот дахь салбарыг Гадаад хэргийн сайдын батлагдсан

төсвийн багцад багтаан Консулын газар болгон өөрчлөн байгуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

**Ерөнхий хувь нийлүүлэгчийг томилох тухай**

Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

өдрийн 8 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн Монголын талын Ерөнхий хувь нийлүүлэгчээр Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдыг томилсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Ерөнхий хувь нийлүүлэгчийг томилох тухай" Засгийн газрын 1999 оны 1 дүгээр сарын 27-ны

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**
**Г. БАТХҮҮ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

**Агентлаг байгуулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрыг байгуулсугай.

2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

байгуулагдсантай холбогдуулан Хөдөлмөр эрхлэлтийн газар, Улсын нийгмийн халамжийн газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгаж орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба, нийгмийн халамж, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

**Засгийн газрын агентлаг байгуулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрыг байгуулсугай.

2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар байгуулагдсантай холбогдуулан Шуудан,

цахилгаан холбооны газрыг татан буулгах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсугай.

3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын шууд харьяанд Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төвийг байгуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**
**С.БАЯРЦОГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

бичгийн даргаар түр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**

Пүрэвсамбуугийн Батсайханыг Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**
**Г.БАТХҮҮ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

байгууллагын яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**

Тошооны Самбасанчирыг Барилга, хот

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙД**
**Н.БАТБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

### Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

үүргийг Гадаад хэргийн яамны тухайн орныг хариуцсан ажилтан гүйцэтгэж байхаар тус тус тогтоосугай.

1. Монгол Улсын Засгийн газар, гадаад орны Засгийн газар хооронд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

4. Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байхыг Сангийн сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

2. Тухайн оронтой явуулж байгаа хамтын ажиллагааны цар хүрээ, зонхилох чиглэл, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай уялдуулан хуралдаанд Монголын талаас оролцох төлөөлөгч, шинжээчдийн бүрэлдэхүүнийг комиссын Монголын хэсгийн дарга тухай бүр томилж байхаар тогтоосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**

3. Монгол-Орос, Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн нарийн бичгийн дарга нарын газрын бүрэлдэхүүнийг Монголын хэсгийн дарга томилж байхаар, бусад комиссын Монголын хэсгийн нарийн бичгийн даргын

**ГАДААД ХЭРГИЙН  
САЙД**
**Ц.МӨНХ-ОРГИЛ**



## Засгийн газрын 2004 оны 214 дүгээр тогтоолын хавсралт

### ХУДАЛДАА-ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОМИССУУДЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН

1. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Үйлдвэр, худалдааны сайд

Орлогч дарга Гадаад хэргийн дэд сайд

2. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд

Орлогч дарга Үйлдвэр, худалдааны дэд сайд

3. Монгол Улс-Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан Хорооны Монголын хэсэг

Дарга Шадар сайд

4. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол-Италийн Засгийн газар хоорондын холимог Комиссын Монголын хэсэг

Дарга Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд

5. Худалдаа-эдийн засгийн талаар хамтран ажиллах Монгол-Болгарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

6. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Украины Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Түлш, эрчим хүчний сайд

7. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Унгарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд

8. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

9. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

10. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Хүнс, хөдөө аж ахуйн сайд

11. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Кубын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Эрүүл мэндийн сайд

12. Монгол-Туркийн эдийн засаг, худалдааны хамтарсан Хорооны Монголын хэсэг

Дарга Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

13. Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Финландын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Гадаад хэргийн дэд сайд

14. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Беларусийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Түлш, эрчим хүчний сайд

15. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Чехийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Барилга, хот байгуулалтын сайд

16. Монгол Улс-Арабын орнуудын хамтын ажиллагааны Комиссын Монголын хэсэг

Дарга Байгаль орчны сайд

17. Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Үйлдвэр, худалдааны дэд сайд

18. Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Батлан хамгаалахын сайд

19. Монгол Улс-Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга Хууль зүй, дотоод хэргийн сайд

20. Монгол-Британийн дугуй ширээний ярилцлагын Монголын хэсэг

Дарга Гадаад хэргийн дэд сайд

21. Монгол-Канадын дугуй ширээний ярилцлагын Монголын хэсэг

Дарга Барилга, хот байгуулалтын сайд

22. Монгол Улс-ХБНГУ-ын Зээл тусламжийн асуудал зохицуулах хэлэлцээний Монголын хэсэг

Дарга Сангийн сайд

23. Монгол-Францын Соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны хамтарсан Комиссын Монголын хэсэг

Дарга Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

24. Монгол-Энэтхэгийн хамтын ажиллагааны хамтарсан Хорооны Монголын хэсэг

Дарга Гадаад хэргийн дэд сайд

25. Монгол-Оросын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд Комиссын Монголын хэсэг

Дарга Үйлдвэр, худалдааны дэд сайд

26. Монгол Улс-Европын Холбооны хамтын ажиллагааны Хамтарсан Хорооны дэргэдэх худалдаа, хөрөнгө оруулалтын дэд Хорооны Монголын хэсэг

Дарга Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

### Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ Хэлэлцээр"-ийг баталсугай.

нь:

Каир хотноо 2004 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан "Хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хоорондын

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ГАДААД ХЭРГИЙН  
САЙД**

**Ц.МӨНХ-ОРГИЛ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

мэндийн дэд сайдын албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Ажханы Болатыг Монгол Улсын Байгаль эрчны дэд сайдын, Уртнасангийн Уламбаярыг Монгол Улсын Дэд бүтцийн дэд сайдын, Очирын Эрдэнийг Монгол Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайдын, Нацагийн Удвалыг Монгол Улсын Эрүүл

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР  
САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАЯРЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

7. Шагдарсүрэнгийн Энхбатыг Монгол Улсын Эрүүл мэндийн дэд сайдын.

Дор дурдсан хүмүүсийг дараахь албан тушаалд томилсугай:

1. Донногийн Цогт-Очирыг Монгол Улсын Байгаль орчны дэд сайдын;

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

2. Авирмэдийн Баттөрийг Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайдын;

3. Сономцэрэнгийн Мэндсайханыг Монгол Улсын Түлш, эрчим хүчний дэд сайдын;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР  
САЙД

Ч.УЛААН

4. Цагаандарийн Энхтүвшинг Монгол Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайдын;

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАЯРЦОГТ

5. Цэдэнжавын Сүхбаатарыг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдын;

6. Цэрэндоржийн Ганхуягийг Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайдын;



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

Түдэвийн Цэрэнпүрэвийг Түлш, эрчим

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ  
САЙД

Т.ОЧИРХҮҮ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

томилсугай.

Шаравдоржийн Түвдэндоржийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргаар түр

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАЯРЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

### Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрыг байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 12 дугаар зүйл, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэмжээг 2004 оны хөрөнгө оруулалтын нийт дүнд зохицуулж шийдвэрлэхийг Сангийн сайд Н.Алтанхуягт даалгасугай.

1. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрыг байгуулсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

Ч.УЛААН

2. Шинээр байгуулагдаж байгаа Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах үндсэн болон эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмжөөр хангах арга

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 004 оны 11 дүгээр  
арын 17-ны өдөр

Дугаар 223

 Улаанбаатар  
хот

**2005 оныг "Бичил санхүү, жижиг,  
дунд бизнесийг дэмжих жил"  
болгон зарлах тухай**

 Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
нь:

 1. 2005 оныг "Бичил санхүү, жижиг, дунд  
бизнесийг дэмжих жил" болгон зарласугай.

 2. "Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг  
дэмжих жил"-ийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө,  
/г ажлыг удирдан зохицуулах үндэсний хорооны  
Зуралдэхүүний талаар санал боловсруулж Засгийн  
азарт оруулахыг Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-  
Эргил, Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд,  
Сангийн сайд Н.Алтанхуяг нарт тус тус даалгасугай.

 3. "Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг  
дэмжих жил"-ийн хүрээнд зохиогдох арга хэмжээг  
дэмжиж ажиллахыг Монгол банкны Ерөнхийлөгч  
О.Чулуунбатад зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**ГАДААД ХЭРГИЙН  
САЙД**
**Ц.МӨНХ-ОРГИЛ**
**САНГИЙН САЙД**
**Н.АЛТАНХУЯГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2004 оны 12 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 230

 Улаанбаатар  
хот

**Жагсаалтад нэмэлт оруулах тухай**

 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн  
17.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас  
тогтоох нь:

 "13.Алтан-Өлгий дэх оршуулгын газар" гэж  
нэмсүгэй.

 Засгийн газрын 1998 оны 235 дугаар  
тогтоолоор батлагдсан "Улс, аймаг, нийслэлийн  
хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх  
дурсгалын жагсаалт"-ын 21-ийн "Улсын  
хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал" хэсэгт

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**
**П. ЦАГААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2004 оны 12 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 231

 Улаанбаатар  
хот

**Жагсаалтад нэмэлт оруулах тухай**

 Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
нь:

 хуваарилагдаагүй зардлаас гаргажцаашид улсын  
төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайд Н.  
Алтанхуягт даалгасугай.

 1. Засгийн газрын 2004 оны 135 дугаар  
тогтоолоор батлагдсан "Цагдаа, дотоодын цэргийн  
хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт"-  
ын "Нэг"-д "7. Алтан-Өлгий дэх оршуулгын газар."  
гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**САНГИЙН САЙД**
**Н.АЛТАНХУЯГ**

 2. Хамгаалалтын үйл ажиллагаанд  
шаардагдах 17.9 /арван долоон сая есөн зуун  
мянган/ сая төгрөгийг улсын төвлөрсөн төсвийн

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**
**П. ЦАГААН**

 Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

 Улаанбаатар-12,  
Төрийн эрдэнэ  
☎ 329612

Индекс 14003

 Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5